

## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ

- ◆ Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх
- ◆ Тэтгэмж бодох хувь хэмжээ
- ◆ Тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах
- ◆ Нийтлэг асуулт-хариулт



## Ажилгүйдлийн ТЭТГЭМЖ авах



### Тэтгэмж авах эрх

Даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажилгүй болохоос өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн, хөдөлмөрийн байгууллагад “ажил хайгч иргэн”-ээр бүртгүүлснээр ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрхтэй.

### Тэтгэмж дахин авах эрх

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлснөөр ажилгүйдлийн тэтгэмж авах, мэргэжлийн сургалтад хамрагдах эрх нь дахин үүснэ.

### Тэтгэмж авах хугацаа, хувь хэмжээ

Ажилгүйдлийн тэтгэмжийг шимтгэл төлсөн сүүлийн 3 сарын хөдөлмөрийн хөлс, орлогын дунджаас шимтгэл төлсөн хугацаанаас хамааран дараах хувиар тооцон, ажлын 76 өдрийн хугацаанд олгоно:

Шимтгэл төлж ажилласан хугацаа	Тэтгэмж бодох хувь хэмжээ
5 хүртэл жил	45%
5-10 жил	50%
10-15 хүртэл жил	60%
15, түүнээс дээш жил	70%



---

### Мэргэжил олгох, давтан сургалт

Ажилгүйдлийн тэтгэмж авах болзол хангасан даатгуулагч ажилгүй болсноос хойш 6 сарын дотор мэргэжил олгох болон давтан сургалтад хамрагдах хүсэлтээ оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөрийн байгууллагад гаргавал сургалтын зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас төлнө.

---

### Тэтгэмж авах хүсэлт гаргах

Даатгуулагч ажлаас чөлөөлөгдсөн тушаал, шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлнэ.

Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ 14 хоногийн дотор [daatguulagch.ndaatgal.mn](http://daatguulagch.ndaatgal.mn), [e-mongolia.mn](http://e-mongolia.mn) веб эсвэл [e-mongolia](http://e-mongolia) аппликейшний тусламжтайгаар цахимаар эсвэл оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ Нийгмийн даатгалын хэлтэст биеэр хандаж гаргана.

---

### Баримт бичиг

Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн тухай тодорхойлолт.
- Тэтгэмж олгохыг хүссэн өргөдөл;
- Ажлаас чөлөөлсөн тухай шийдвэр.



<https://daatguulagch.ndaatgal.mn>

**Алхам 1.**

**Даатгуулагчид зориулсан вебд нэвтрэх**  
“Даатгуулагчид зориулсан веб”-д бүртгүүлсэн буюу “Нийгмийн даатгал” аппликейшний эрхээр эсвэл “ДАН” танилт нэвтрэлтийн систем (удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр)-ээр нэвтрэнэ.

**Алхам 2.**

**Үйлчилгээ сонгох**  
“Тэтгэмж” → “Ажилгүйдлийн тэтгэмж”-ийг сонгоно.

**Алхам 3.**

**Хүсэлт илгээх**  
Дэлгэцэнд даатгуулагчийн Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн мэдээллийг шалган харуулна.

Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй бол даатгуулагч өргөдлийн маягтын дагуу (1) утасны дугаар, и-мэйл хаяг, банкны дансны мэдээллийг бөглөнө; (2) ажлаас чөлөөлөгдсөн тушаал, тооцоо нийлсэн акт (байгаа тохиолдолд)-ыг хавсаргана; (3) ажлаас чөлөөлөгдсөн болон ажил олгогчтой тооцоо хийж дууссан огноог үнэн зөв, бүрэн оруулна.

Мэдээллээ үнэн зөв оруулж, тэтгэмж авах хүсэлтийг цахимаар гаргахыг зөвшөөрсөн тэмдэглэгээ хийн “хүсэлт илгээх” товчийг дарна. Амжилттай илгээгдсэн бол “хүсэлт илгээгдсэн” төлөвт шилжинэ.

**Алхам 4.**

**Хүсэлт баталгаажсан эсэхийг шалгах**  
Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг хянан баталгаажуулж, тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд тэтгэмжийг хуулийн хугацаанд бодож олгоход “хүсэлт баталгаажсан”, тэтгэмж авах эрх үүсээгүй тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжинэ.

### Алхам 1.

#### Порталд нэвтрэх

Нэвтрэх товч дээр дарахад ДАН Үндэсний танилт нэвтрэлтийн системийн цонх харагдах бөгөөд нэг удаагийн нууц код, тоон гарын үсэг, банкны эрхээр нэвтрэх боломжоос сонголт хийнэ.

- i. Нэг удаагийн нууц үгээр нэвтрэх бол регистрийн дугаар, нууц үгийг оруулан Таны нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаарт ирсэн 6 орон бүхий нууц кодыг оруулан бүртгүүлнэ. Бүртгэл амжилттай болсны дараа дахин нэвтэрч өөрийн мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.
- ii. Тоон гарын үсгээр нэвтрэх бол тоон гарын үсэг тээгч э-токен төхөөрөмжийг компьютерт залгаж токены нууц дугаарыг хийж Таны мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.
- iii. Банкны эрхээр нэвтрэх бол харилцагч банкыг сонгон нэвтэрч Таны мэдээллийг ашиглахыг зөвшөөрөх товчийг дарна.

### Алхам 2.

#### Үйлчилгээ сонгох

“Үйлчилгээнүүд” → ”Нийгмийн хамгаалал” → “Даатгал”  
→ “Ажилгүйдлийн тэтгэмж”-ийг сонгоно.

### Алхам 3.

#### Үйлчилгээ авах

- Дэлгэцэнд даатгуулагчийн Хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлсэн мэдээллийг шалган харуулна.
- Хөдөлмөрийн байгууллагад бүртгэлтэй бол даатгуулагч өргөдлийн маягтын дагуу (1) утасны дугаар, и-мэйл хаяг, банкны дансны мэдээллийг бөглөнө; (2) ажлаас чөлөөлөгдсөн тушаал, тооцоо нийлсэн акт (байгаа тохиолдолд)-ыг хавсаргана; (3) ажлаас чөлөөлөгдсөн болон ажил олгогчтой тооцоо хийж дууссан огноог үнэн зөв, бүрэн оруулна.

Мэдээллээ үнэн зөв оруулж, тэтгэмж авах хүсэлтийг цахимаар гаргахыг зөвшөөрсөн тэмдэглэгээ хийн “хүсэлт илгээх” товчийг дарна. Амжилттай илгээгдсэн бол “амжилттай” төлөвт шилжинэ.

### Алхам 4.

#### Хүсэлт баталгаажсан эсэхийг шалгах

Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчийн тэтгэмж авах хүсэлтийг хянан баталгаажуулж, тэтгэмж авах эрх үүссэн тохиолдолд тэтгэмжийг хуулийн хугацаанд бодож олгоход “хүсэлт баталгаажсан”, тэтгэмж авах эрх үүсээгүй тохиолдолд “буцаасан” төлөвт тус тус шилжинэ.

Хүсэлтийн төлөвийг <https://daatgulagch.ndaatgal.mn/#/main/view/unemployment/dashboard> хаягаар шалгах боломжтой.

---

## Нийтлэг асуулт- хариулт



**Ажилд орсон  
тохиолдолд  
ажилгүйдлийн  
тэтгэмж зогсох уу?**

Тийм. Ажилгүйдлийн тэтгэмж нь ажилгүй болсон даатгуулагчийг дараагийн ажилд орж орлоготой болох хүртэлх хуулиар тогтоосон хугацаанд амьдралын баталгааны эх үүсвэрийг хангах зорилготой.

Тиймээс ажилгүйдлийн тэтгэмж авч буй даатгуулагч ажилд орсон бол түүний тэтгэмжийг ажилд орсон өдрөөс эхлэн зогсооно.

**Ажилгүйдлийн  
тэтгэмжийг сард  
хэдэн удаа олгох вэ?**

Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлын 76 өдрийн хугацаанд олгох бөгөөд тухайн сард ногдох тэтгэмжийг 2 хүртэлх удаа тооцож олгоно.

**Урьд нь  
ажилгүйдлийн  
тэтгэмж авч байсан  
бол дахин  
ажилгүйдлийн  
тэтгэмж авах  
боломжтой юу?**

Урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авч байсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг 12 сараас доошгүй хугацаагаар төлөөд ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж дахин авах эрх үүснэ.